

ГЕРМАН-МОНГОЛЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
“ТОГТВОРТОЙ ХӨДӨӨ АЖ АХУЙ” ТӨСЛИЙН
III ҮЕ ШАТНЫ 2020 ОНЫ ТАЙЛАН

2021 оны 02 дугаар сарын 28

№	Хөтөлбөр/ төслийн агуулга	Гүйцэтгэл
1.	Төслийн нэр: Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” төсөл MNG-19 01	Төслийн үндсэн /хөгжлийн/ зорилго: ХБНГУ болон Монгол Улсын хөдөө аж ахуйн салбар дахь хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх яриа хэлэлцээр, холбогдох үйл ажиллагаанууд нь Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарын эдийн засаг, нийгэм, экологийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлнэ.
2.	Санхүүгийн эх үүсвэр	ХБНГУ-ын Холбооны хүнс, хөдөө аж ахуйн яамны буцалтгүй тусламж
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Төслийг дэмжигч байгууллага: Холбооны Хүнс, хөдөө аж ахуйн яам (ГФА Консалтинг групп яамыг төлөөлж төслийн ерөнхий захиалагчаар ажилладаг) Гол түншлэгч байгууллага: ХХААХҮЯ, ХААИС, УГТХ, МХЕГ, Үндэсний давхар даатгал ХК Хэрэгжүүлэгч байгууллага: ИАК Аграр Консалтинг ХХК-ийн удирдлагаар Агрикалче энд Файнэнс Консалтанс ХХК, ДЛЖ Интернэйшнл ХХК Хугацаа: 2019 оны 01 сараас 2021 оны 12 сар
4.	Төслийн зорилго, шалгуур үзүүлэлт	<p>Үр дүн 1: Газар тариалангийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах. Монгол улсын ХХАА-н салбарын эрх зүйн орчныг олон улсын жишигт ойртуулахад тодорхой ахиц гарсан бөгөөд энэ нь ялангуяа таримал ургамлын үр, сортын тогтолцоог бэхжүүлэх, газар тариалангийн зохистой дадал нэвтрүүлэхэд болон ХАА-н эрсдэлийн менежментийг тогтолцоог бий болгоход чиглэсэн хууль, эрх зүйн актуудад тусгагдсан байна.</p> <p>Үр дүн 2: Газар тариалангийн салбарын институцийн чадавхийг бэхжүүлэх. Монгол Улсын ХАА-н салбарын тогтвортой хөгжилд (ялангуяа таримал ургамлын үр, сортын тогтолцоог бэхжүүлэх, газар тариалангийн зохистой дадал нэвтрүүлэхэд болон ХАА-н эрсдэлийн менежментийг тогтолцоог бий болгоход) чухал үүрэгтэй боловч одоогоор хараахан бий болоогүй эсхүл үйл ажиллагаа нь төлөвшөөгүй төрийн эсхүл иргэний нийгмийн буюу хувийн хэвшлийн байгууллагуудыг бий болгох эсхүл чадавхижуулахад чиглэсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар салбарын институцийн орчны хөгжилд дэмжлэг үзүүлнэ.</p> <p>Үр дүн 3: Газар тариалангийн салбарын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх. Монгол улсад таримал ургамлын үр, сортын тогтолцоог бэхжүүлэх, газар тариалангийн зохистой дадлыг нэвтрүүлэхэд болон ХАА-н эрсдэлийн менежментийг төлөвшүүлэхэд шаардагдах</p>

		<p>боловсон хүчний мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, улам гүнзгийрүүлэх, түгээн дэлгэрүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.</p> <p>Үр дүн 4: “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалан” дэд төсөл. Монгол Улс, ХБНГУ-ын газар тариалангийн салбар дахь мэдлэг, туршлага солилцоог идэвхижүүлэх замаар Монгол Улсад байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон газар тариалангийн салбарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулна.</p>		
5.	Зардал	Нийт төсөв	1,460,734 Евро /2019.01.01-2021.12.31 буюу нийт 36 сарын хугацаанд /	
		Тайлант хугацаанд зарцуулсан хөрөнгө	482,588.00 Евро (99.9 %) /2020 оны 01 сарын 01-ээс 2020 оны 12 сарын 31/	
	Үүнд:	Төлөвлөсөн төсөв /Евро/	Зардал /гүйцэтгэлээр/ Евро	Нийт
	Зөвлөх үйлчилгээнд (гадаад, дотоодын богино хугацааны мэргэжилтнүүд)	406,070.00	406,070.00	100%
	Танилцах аялал, талбайн өдөрлөг, сургалт, семинар, хурал зөвлөгөөн	38,138.00	37,898.00	99.4%
	Захиргааны зардал (төслийн нэгжийн урсгал зардал, унаа, харилцаа холбоо)	38,620.00	38,620.00	100%
	НИЙТ ДҮН /Евро/	482,828.00	482,588.00	<u>99.95%</u>
6.	Төслийн зорилт:		Ажлуудын биелэлтийг доорхи талбарт бичсэн.	
	Үр дүн-1		Үнэлгээний тайлангийн 5 дугаар хуудас	
	Үр дүн-2		Үнэлгээний тайлангийн 5-6 дугаар хуудаснаас харна уу.	
	Үр дүн-3		Үнэлгээний тайлангийн 6-7 дугаар хуудаснаас харна уу.	
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)		<p>Төслийн гүйцэтгэлд 2020 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ үнэлгээний хийхэд 86.6 хувьтай биелсэн байна.</p> <p>Тогтвортой хөдөө аж ахуй төслийн III дугаар үе шат хэрэгжсэнээр дараах бодит үр дүнгүүд гарч эхлээд байна.</p> <p>1.“Таримал ургамлын үр, сортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийн хэрэгжилтийг зохицуулах “Сорт сорилт гүйцэтгэх” болон “Шинэ сорт баталгаажуулах” журмын төслүүдийг боловсруулж, ХХААХҮЯ-нд хүлээлгэн өгсөн байна.</p> <p>2.Сорт сорилтын салбарыг сэргээн байгуулахтай холбогдуулан “Улаанбуудай, төмсний сортыг сорих, баталгаажуулах”, “Хөдөө аж ахуйн нэвтрүүлэх үйлчилгээний үндэсний тогтолцооны загвар”, “Хөдөө аж ахуйн салбарт мэдээллийн хүртээмж, чанарыг</p>	

		<p>сайжруулах чиглэл, арга замууд”, “Чанартай үр арвин ургацын үндэс”, “Монгол орны хүнсний ногооны үйлдвэрлэлийн эрсдэлийн удирдлага- боломж, бэрхшээл”, “Монгол орны тариалангийн талбайн хөрс хамгаалал” зэрэг сэдвүүдээр бодлогын зөвлөмж боловсруулан холбогдох газруудад хүргүүлж ажилласан байна.</p> <p>3. Монгол улсад таримал ургамлын үр, сортын тогтолцоог бэхжүүлэх, экстейншний арга зүй-сургагч багш бэлтгэх чиглэлд мөн газар тариалангийн зохистой дадлыг нэвтрүүлэхэд болон ХАА-н эрсдэлийн менежментийг төлөвшүүлэх чиглэлд үр дүнтэй сургалтуудыг зохион байгуулсан байна.</p> <p>Зөвлөмж:</p> <p>1. Шалгуур үзүүлэлт бүрээр хүрсэн түвшинг тайлагнаж хэвших шаардлагатай байна.</p>				
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	Төслийг хэрэгжүүлэгч талууд бололцоо, нөөцөө дайчлан хамтын ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлж ажилласан байна.				
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (тухайн жилийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Үр дүн	Үр дүн 1	Үр дүн 2	Үр дүн 3
		86.6	Хувь	90 %	70 %	100 %
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)	Нэгдсэн үнэлгээ				
		... %				

ТОВЧЛОЛ

ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ХААҮШУОНТ	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төв
ТХАА	Тогтвортой хөдөө аж ахуй
УГТХ	Ургамал, газар тариалангийн хүрээлэн (Дархан)
УХЭШХ	Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн
МУИС	Монгол Улсын их сургууль
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ШУА	Шинжлэх ухааны академи
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХАБҮЛЛ	Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори
ОУБ	Олон Улсын Байгууллага
ХАА	Хөдөө аж ахуй
УХЦА	Ургамал хамгааллын цогц арга
ЭША	Эрдэм шинжилгээний ажилтан

ТӨСЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ҮР ДҮН

Үр дүн 1: Газар тариалангийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах. Монгол улсын газар тариалангийн салбарын эрх зүйн орчныг олон улсын жишигт ойртуулахад тодорхой ахиц гарах бөгөөд энэ нь ялангуяа таримал ургамлын үр, сортын тогтолцоог бэхжүүлэх, газар тариалангийн зохистой дадал нэвтрүүлэхэд болон ХАА-н эрсдэлийн менежментийг тогтолцоог бий болгоход чиглэсэн хууль, эрх зүйн актуудад тусгагдсан байна.

А. Газар тариалангийн салбарын эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хийсэн ажлууд:

- ТХАА төсөл **“Таримал ургамлын үр сортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”**-ийг батлуулах ажилд анхаарал хандуулан олон удаа мэргэжлийн зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллаж байна. Тус хуулийн төсөл УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо /БОХХААБХ/-нд хэлэлцэгдэж байна.
- Дээрх хуулийн төсөл УИХ-аар батлагдахтай холбогдон зохицуулалтын журмууд батлагдах болно. ТХАА төслөөс зарим журмын төслүүдийг боловсруулж, Ажлын хэсэгт хүргүүлсэн болно. Тухайлбал, **“Сорт сорилт гүйцэтгэх”** болон **“Шинэ сорт баталгаажуулах”** журмын төслүүдийг тайлант хугацаанд боловсруулжээ.
- Сорт сорилтын салбарыг сэргээн байгуулахтай холбогдуулан **“Улаанбуудай, төмсний сортыг сорих, баталгаажуулах”** чиглэлээр мэргэжлийн зөвлөмж боловсруулсан.
- ХХААХҮЯ-ны Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтэс /ХУХҮСХ/-т **“Ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”** боловсруулах ажилд мэргэжлийн зөвлөгөө өгч, уг хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.
- ХХААХҮЯ газар тариалангийн хөрс хамгаалах стратеги боловсруулах ажлын эхлүүлсэн. ТХАА төслөөс ХБНГУ-ын газар тариалангийн хөрс хамгаалах хууль эрхзүйн орчны талаарх мэдээллийг хүргүүлжээ.

Үр дүн-1-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 90 хувь

Үр дүн 2: Газар тариалангийн салбарын институцийн чадавхийг бэхжүүлэх. Монгол Улсын ХАА-н салбарын тогтвортой хөгжилд (ялангуяа таримал ургамлын үр, сортын тогтолцоог бэхжүүлэх, газар тариалангийн зохистой дадал нэвтрүүлэхэд болон ХАА-н эрсдэлийн менежментийг тогтолцоог бий болгоход) чухал үүрэгтэй боловч одоогоор хараахан бий болоогүй эсхүл үйл ажиллагаа нь төлөвшөөгүй төрийн эсхүл иргэний нийгмийн буюу хувийн хэвшлийн байгууллагуудыг бий болгох эсхүл чадавхижуулахад чиглэсэн зөвлөх үйлчилгээ үзүүлэх замаар салбарын институцийн орчны хөгжилд дэмжлэг үзүүлнэ.

- Монгол оронд Таримал ургамлын сорт сорилтын салбарыг сэргээн байгуулахад зориулан **“Сорт сорилтын төв байгуулахад өгөх зөвлөмж”, “Сорт сорилт гүйцэтгэх, сорт сорилтын төвд тавигдах шаардлагууд”** сэдэвт зөвлөмжүүдийг боловсруулахад Холбооны сортын агентлаг /ХСА/-ийн мэргэжилтнүүдтэй хамтран ажиллалаа.

- ТХАА төслөөс “**Үр тариа, тос, тэжээлийн ургамлын тариалан эрхлэгчдэд зориулсан тариалангийн зохистой дадал эзэмшүүлэх**” сургалтын нэгдсэн төлөвлөгөө боловсрууллаа. Уг төлөвлөгөө нь ХХААХҮ-ийн Судалгаа хөгжлийн төвийн сургалт, мэдээллийн үйл ажиллагаанд тодорхой хувь нэмэр оруулах болно.
- Үндэсний газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий Монголын Тариаланчдын Үндэсний Холбоо /МТҮХ/-ны өнөөгийн бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцөд дүн шинжилгээ, үнэлэлт, дүгнэлт хийж, түүнийг боловсонгуй болгох чиглэлээр санал, зөвлөмж боловсруулж, “**МТҮХ-ны стратеги төлөвлөгөө**”-г боловсруулж хүлээлгэн өглөө.

Үр дүн-2-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 70 хувь

Үр дүн 3: Газар тариалангийн салбарын боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх.

Монгол улсад таримал ургамлын үр, сортын тогтолцоог бэхжүүлэх, газар тариалангийн зохистой дадлыг нэвтрүүлэхэд болон ХАА-н эрсдэлийн менежментийг төлөвшүүлэхэд шаардагдах боловсон хүчний мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлж, уг мэдлэг, ур чадварыг цаашид гүнзгийрүүлэх, түгээн дэлгэрүүлэх нөхцлийг бүрдүүлнэ.

Огноо	Үйл ажиллагаа
2020.01.23-24	“ Экстейншний арга зүй-сургагч багш ” сургалтад өмнөх жил оролцоогүй үлдсэн байсан 9 аймаг, нийслэлийн ХХААГ-уудын нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээ хариуцсан мэргэжилтүүд 9 хүнийг хамруулж, “Сургагч багш”-аар бэлтгэжээ.
2020.06.11-12	Дээрх сургалтын дадлага сургалт болох “ Газар тариалангийн сургалт, нэвтрүүлэлтийн арга зүй ” талбайн сургалтыг Дархан-Уул аймгийн Орхон, Хонгор сумдад зохион байгуулж, Төв, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул аймгуудын экстейншин хариуцсан мэргэжилтэн, сургагч багш нар оролцон, 30 гаруй ногоочдыг сургалтад хамруулж мэдлэг олгожээ.
2020.07.21-22	“ Хүнсний ногооны аж ахуй эрхлэх зохистой дадал ” –Баруун бүсийн сургалтыг ХХААХҮЯ-ны ХУХҮС-ын хэлтэс, Завхан аймгийн ЗДТГ, УХЭШХ-тэй хамтран Завхан аймгийн Улиастай хотод зохион байгуулж, Увс, Ховд, Завхан аймгийн нийт 90 орчим хүнсний ногооны тариаланчид, агрономчдыг хамрууллаа.
2020.08.13-14	“ Газар тариалангийн сургалт, нэвтрүүлэлтийн арга зүй ” талбайн сургалтыг Хөвсгөл аймагт зохион байгуулж, Хөвсгөл, Хэнтий, Говьсүмбэр, Дундговь, Баянхонгор аймгуудын экстейншн хариуцсан мэргэжилтнүүд, Тариалан сумын агрономчид зэрэг 30 гаруй ногоочдыг сургалтад хамруулжээ.
2020.10.22	“ Үр тариа, тос, тэжээлийн ургамлын тариалан эрхлэгчдэд зориулсан тариалангийн зохистой дадал эзэмшүүлэх ” сургалтын нэгдсэн төлөвлөгөөний төслийг ХХААХҮ-ийн Судалгаа хөгжлийн төвд ХХААХҮЯ, ХААИС, МТҮХ, тариалан бүхий зарим аймгуудын агрономчид, хувийн хэвшлийн төлөөллүүдийг оролцуулан хэлэлцүүлжээ.
2020.12	“Байцааны тариалалтад ХААЗД нэвтрүүлэх” сэдэвт онлайн сургалтыг УХЭШХ-тэй хамтран бэлтгэж, төслийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргээд байна. https://www.dmknl.de/mn/bajcaany-tarialaltad-h-d-az-ahujn-zohistoj-dadal-nevtr-leh.html

2020.12	<p>“Бөөрөнхий сонгины тариалалтад ХААЗД нэвтрүүлэх” сэдэвт онлайн сургалтыг УХЭШХ-тэй хамтран бэлтгэж, төслийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргээд байна.</p> <p>https://www.dmknl.de/mn/bajcaany-tarialtad-h-d-az-ahujn-zohistoj-dadal-nevtr-leh.html</p>
---------	---

Үр дүн-3-ын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 100 хувь

Д. Төслийн хүрээнд зохион байгуулсан бусад ажлууд:

Огноо	Үйл ажиллагаа
2020.07-08 сард	“Монгол орны хүнсний ногооны үйлдвэрлэлийн эрсдэлийн удирдлага-боломж, бэрхшээл” сэдэвт судалгааг Төв, Сэлэнгэ, Орхон, Дархан-Уул, Ховд, Увс, Завхан аймгуудын 300 гаруй хүнсний ногоо тариалагчдыг хамруулан асуумж, ярилцлага хэлбэрээр зохион байгууллаа.
2020.11-12 сар	Монголын газар тариалан, хөдөө аж ахуйн техникийн салбарт ажиллагсдын залгамж халааг бэлтгэх, тэдний ажлын байрны хангамжийг судлах, үнэлэх судалгааны ажлыг зохион байгуулсан.
2020.12 сар	Дэлхий нийтэд тархаад буй Ковид-19 цар тахлын улмаас олон нийтийг хамруулсан сургалт, зөвлөгөөн зохион байгуулах боломжгүй болсон тул “Цахим хөдөө аж ахуй - Ухаалаг газар тариалан” сэдэвт виртуал танилцах аяллыг бэлтгэн олон нийтэд нийтэд хүргэхэд бэлэн болгосон. Энэхүү контентэд ХБНГУ-ын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, дижитал хөдөө аж ахуйн шинэ технологиуд, ирээдүйд чиглэсэн бүтээн байгуулалтуудын талаар ярилцлага, видео, илтгэл, танилцуулга үзүүлэх хэлбэрээр бэлтгэсэн бөгөөд түүнийг монгол хэлээр орчуулан, диктороор текстийг уншуулан, төслийн цахим хуудаст байршуулсан.

ХУНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ